



**БУЛГАН АЙМГИЙН  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,  
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082  
Утас/Факс: 7034-2580  
E-mail: bulgan@audit.gov.mn

БУЛГАН СУМЫН "ЭМИЙН  
ЦЭЦЭГЛЭН" ББН ӨРХИЙН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН  
ДАРГА Э.ЭНХЖАРГАЛ ТАНАА

2024. 03. 15 № 305

танай \_\_\_\_\_ ны № \_\_\_\_\_ т

**Дүгнэлт өгөхөөс татгалзсан**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Булган сумын "Эмийн цэцэглэн" ББН өрхийн эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийхээр төлөвлөсөн.

Булган сумын "Эмийн цэцэглэн" ББН өрхийн эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөхөөс татгалзаж байна. Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь санхүүгийн тайланд материаллагаар нөлөөлсөн ба өргөн тархсан гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд дүгнэлт өгөх хангалттай, зохистой аудитын нотолгоо олж авах боломжгүй байна.

**Дүгнэлт өгөхөөс татгалзсан үндэслэл**

Тус байгууллагын санхүүгийн тайланд аудит хийхэд хангалттай, зохистой аудитын нотолгоо олж авах боломжгүй нөхцөл байдал үүссэн. Үүнд:

- Булган сумын "Эмийн цэцэглэн" ББН өрхийн эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг хуулийн цаглаварт хугацаанд ирүүлээгүй,
- Санхүүгийн тайланг гаргахдаа журнал бүртгэлийг нийт дүнгээр хөтөлсөн,
- Бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудтай тооцоо нийлсэн актгүй,
- Тооллого хийх комисс томилсон тушаалгүй, тооллогын үр дүнг тайлагнасан тайлан байхгүй,
- Тооллогын тооцоо бодсон баримт байхгүй,
- Тайлант хугацаанд хөрөнгийг дахин үнэлсэн гэх боловч холбогдох тушаал, шийдвэргүй,
- Санхүүгийн тайлантай холбоотой бүтэц орон тоонд оруулсан өөрчлөлт, үр дүн олгох журам болон гишүүд, ажилчдыг үнэлсэн нөхөрлөлийн хурлын тэмдэглэл, даргын тушаал байхгүй,
- Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй зэрэг нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 13 дугаар зүйлийн 13.1, 13.6, 13.7, 18 дугаар зүйлийн 18.1, 20 дугаар зүйлийн 20.2.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2, 72 дугаар зүйлийн 72.4,

006020699

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8, Нөхөрлөлийн тухай хуулийн 22 дугаар зүйл 22, УСНББОУС-1, 12, 17, санхүүгийн тайлангийн аудитын үнэлгээ ба хуваарилалт, иж бүрэн байх, толилуулга, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой байсан.

Гэвч, дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн улмаас санхүүгийн тайланд дүгнэлт өгөхөд үндэслэл болохуйц хангалттай бөгөөд зохистой нотолгоо олж авах боломжгүй байна.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.ЭРДЭНЭ